

Монголын “Дундат зуун”

Доктор /PhD/, дэд профессор У.Гонгоржав

Түүхийн шинжлэх ухаанд байгаа “дундат зуун” хэмээх нэр томъёо анх Европын сэтгэгчид гуманистуудын дунд XV зууны үед үүсчээ. Тэр үеийн гуманистуудын эртний Герег, Ромын үед хүн төрөлхтний соёл иргэншил цэцэглэн хөгжиж байснаа V зууны үед уналтанд орж өөрсдийнхөө үеэс XV-XVI зууны дахин сэргэсэн гэж үзээд, V-XV зууны хоорондох үеийг “дундат зуун” /medium ovum/ хэмээн нэрлэсэн байна. Энэ үеэс түүхийн ухаанд эрт, дундат, шинэ үе хэмээх ухагдахуун буй болж, агуулга, онол арга зүйн хувьд баяжин хөгжиж иржээ. Эхэндээ зөвхөн Европийн түүхнээ хэрэглэгдэж байсан энэ нэр түүхийн шинжлэх ухааны хөгжлийн явцад яваандаа дэлхийн түүхэнд хэрэглэгдэх болсон юм. Энэ өнцөгөөс авч үзвэл Монголын түүхэнд “Дундат зуун” байсан уу? Байсан бол хэдийгээс эхэлж хэдийд дууссан, түүний бусад улсын дундат зууны түүхэн хөгжилтэй хэрхэн уялдах хийгээд өөрийн онцлог, өвөрмөц тал буй өсөх, түүний дэлхий дахины түүхэн үйл явцад ямар байр суурь эзлэх зэрэг олон асуултууд урган гарч ирж байна.

“Эрт”, Дундат зууны” зааг дээр эртний суурьшмал соёл иргэншлийг төлөөлсөн таван томоохон улс байсан нь: Хятадын Хан, Энэтхэгийн Гуптын хаант улс Дундат Азийн Кушаны хаант улс, Иран, Хоёр мөрний савын Парфийн хаант улс, Өрнөд Ази, Умарт Африк, Баруун Европын эзэгнэсэн Ром гүрэн эдгээр болно. Хан, Парфийн хаант улсууд III зуунд, бусад нь V зуунд задран мөхөж, эртний үе шувтарчээ. Иймээс ерөнхийдөө III зууны үеэс дэлхийн “дундат зуун” эхэлсэн гэж янз бүрийн онол, үзэл, урсгалыг төлөөлдөг түүхч эрдэмтэд үздэг байна.

Тэгвэл энэ үед хуучин тивд олон угсааны нүүдэлчин ард түмэн бас өөрийн улс, төрийн бүрдлүүдийг байгуулж, эртний дэлхийн түүхэн үйл явцад идэвхтэй оролцож байлаа.

Төв Азийн Хүннү нар эртний Хан улсын мөхөхөд их үүрэг гүйцэтгэсэн бол нүүдэлчдэд шахагдсан дорнод Европын бүдүүлэг аймгууд /барбари/ Ромын эзэнт гүрний мөхөлд шийдвэрлэх үүрэг гүйцэтгэсэн билээ. Арабын нүүдэлчид ч энэ хэрэгт бас оролцож, Пирнейн хойгийг эзлэн авч Европын баруун хэсэгт өөрийн Халифт улсыг байгуулсан нь хожим Испани, Португаль гэж дундат зууны томоохон улсууд байгуулагдахад их үүрэг гүйцэтгэсэн билээ.

“Дундат зуун” бол эртний соёл иргэншлийн суурин дээр нийгэм-эдийн засаг, соёлын илүү өндөр шат болох феодалын нийгэм үүсч хөгжин, унасан үе гэж түүхийн шинжлэх ухаанд үздэг бөгөөд түүхийн ихэнх ном зохиолуудад XVI-XVII зууны эхэн хагаст дуусч дараагийн “шинэ үе” эхэлсэн гэж нэгэн дуугаар бичигдсэн үзэгдэнэ.

Чингэвэл Монголд “дундат зуун” хэдийд эхэлсэн бэ? Хүн овгийн байгууллаас ангид нийгэмд шилжих үйл явц Төв Азид МЭӨ III зуунаас эхэлжээ. Өвөг Монголчуудын хувьд, Баруун, Европын бүдүүлэг аймгууд шиг суурьшмал байдалд орсны дараа сая феодалын харилцаа төлөвшин хөгжөөгүй, харин “дан ганц нүүдлийн эдийн засгийн бааз дээр үүссэн<sup>1</sup> онцлогтой. Эртний нүүдэлчдийн нийгмийн харилцааны асуудлыг дотоод гадаадын олон эрдэмтэд судалсны дотор “нүүдлийн феодализмын” онцлог, түүний эхэлсэн он цагийн талаар өнөө хир нэг саналтай болоогүй байна. Эрдэмтэн Г.Сүхбаатар Хүннү, Сяньбин нийгмийг феодалын түрүү үеийн шатанд орсон гэж үзсэн Өрнөдийн эрдэмтэд А.В.Давыдова “Об общественном строе Хунну Вкн: Первобытная археология Сибири. Л.1975. с.145. А.Бернштам. К вопросу с социальным строем восточных гуннов. МДО 1935. № 9-10. с.229-231 гэх мэт” тэдний нийгмийг овгийн байгууллын уламжлалыг үлэмжхэн хадгалсан, нилээд бүдүүлэгдүү тэр улс байсан гэж байхад, эрдэмтэн Н.Ишжамц “Хүннү, Сяньби, Моюн, Тоба нарын нийгмийг монгол нутагт анх үүсэн хөгжиж байсан байдлаар нь жинхэнэ ангит нийгэм, тэр улс гэхэд учир дутагдалтай байж болно. Яагаад гэвэл Хүннү, Сяньби нар олон талаар III-V зууны Баруун Европын бүдүүлэг

<sup>1</sup> Ш.Нацагдорж. Монголын феодализмын үдсэн замнал. УБ., 1978. х-33.

ванлигуудтай төсөөтэй байжээ"<sup>2</sup> гэж цохон заажээ. Олон баримт дурьдсан. Түүний бодлоор бол "Монголд бий болсон феодалын түрүү үеийн маягийн анхны ангит нийгэм нь даруй IV-VI зууны үед оршиж байсан Жужаны хаант улс мөн"<sup>3</sup> ажээ.

Ингэж олон зүйл байгаа нь нүүдэлчдийн нийгмийн харилцааны өвөрмөц онцлог, тэдний эдийн засаг, улс төрийн бодлогыг бага харгалзсан тэрхүү харилцааг суурьшмал улсуудын феодализмын үүсэл, хөгжлийн зүй тогтлоор тайлахыг оролдсонтой холбоотой байна. Баруун Европын баруун гот, зүүн гот, лангобард, вандалын ванлигууд Баруун Ромын эзэнт улсын нутаг дээр V-VI зууны үед өөрсдийн улсуудыг байгуулан 30-50 орчим жил оршин тогтоноходоо дөнгөж мөхөж байсан Ромын боолын нийгмийн задрал, феодал маягийн харилцааны үр хөврөл хийгээд өөрсдийн овгийн байгууллын үлдэгдлийг агуулсан шилжилтийн шинжтэй, мэдээжээр дотооддоо ихээхэн зөрчилтэй нийгэмд байлаа. Миний санаад Монгол нутагт тогтох байсан Хүннү, Сяньби улсууд чухам ийм "шилжилтийн" нийгэмд байв. Тэр нь феодалын өмнөх нийгмийн харилцаа бөгөөд үнэхээр олон талаараа бүдүүлэг аймгийн ванлигуудтай адил буюу төстэй байна. Тэдний нийгэмд хуучин овог аймгийн харилцааны үлдэгдэл их байсны дээр бас боолчлох ёсон үүсч байсан ч нүүдэлчдийн ахуйн хэрэгцээнд суурин орнуудын шиг олон тооны боол зарц нар төдий л шаардлагагүй, харин үүслийн төдий байсан эзэн харьяатын харилцаа илүү мэдрэгдэж эхэлж байсан нь тэдгээртэрийн бүрдлүүдийн эдийн засаг, улс төрийн бодлогоос тодорхой байгаа билээ.

Ингэхлээр бид доктор Н.Ишжамцын үзсэнчлэн монголын "дундат" зууныг IV зууны үеэс эхэлсэн гэж үзэж байна. Энэ нь нэгдүгээрт Нирун /Жужан/ улсын эдийн засаг, нийгэм улс төрийн амьдралд феодалын ёсон илт давамгайлан төлөвшсөн.

Хоёрдугаарт: Хэдийгээр тэд 555 онд мөхсөн ч гэсэн Монгол улсын нутгийн зүүн, зүүн урд, зүүн хойт хэсэгт Түрэг угсааны улсуудын хилийн гадна гол цөм нь үлдэж, төр, ахуй, зан суртахуун, соёлоо хадгалан Их Монгол улсын үед хүрч ирсэн.

Гуравдугаарт: Төв Азийн нүүдэлчдийн улсуудын хөрш, суурин соёлт иргэншлийн улсуудтай тогтоосон эдийн засаг, улс төр, соёлын харилцаа нь тэдний нийгэм-эдийн засгийн илүү дэвшилтэд байгуулал үүсэн хөгжихэд нөлөөлсөн. Шинэ залуу феодалын нийгмийн төлөвшилтэд дэлхийн томоохон шашны давхрага маш чухал үүрэг гүйцэтгэсний адил "нүүдлийн феодализмын" төлөвшилтэд бурхны шашин баагай үүрэгтэй байв. Хэдийвээр буддын шашин Энэтхэгээс Дундат Азиар дамжин бүр Хүннүгийн үеэс нүүдэлчдийн дунд дэлгэрч эхэлсэн боловч чухам Нирун улсын үесд төрийн системд "хар ёс" алба ёсоор дэлгэрч, уламжлалт бөө мөргөлийг шахах хандлага анх буй болж, ноёрхогч ангийн үзэл суртлын зэвсэг болов.

Дөрөвдүгээрт: Энэ он цаг нь дэлхийн "дундат зуун"-ы эхэлсэн он цагтай үндсэндээ дүйж байна. Ингэхлээр хуучин тивийн янз бүрийн угсааны суурьшмал, нүүдэлчин ард түмэн бараг нэгэн зэрэг "дундат зуун"-д шилжин оржээ.

Дундат зуун судлалд, дундат зууны ертөнцийн янз бүрийн улсуудад харилцан адилгүй хугацаанд феодализм бүрэлдэн тогтсон, түүний хөгжсөн нөхцөл байдал ч, хөгжлийн төвшин нь ч ижилгүй, нийгэм-эдийн засгийн мөн чанар нь ч мөн л янз байсныг хүлээн зөвшөөрдөг юм. Иймээс ч улс орон бүхэнд "дундат зуун" харилцан өөр өөр хугацаанд үүсч, хөгжиж, дууссан буй. Энэ үеийг огт дамжаагүй ард түмэн Америк, Африк, Австралийн тивүүдэд бий. Евроазийн улсууд л дэлхийн эрт, дундат үеийн соёлт иргэншлийг тодорхойлж иржээ. Энэхүү түүхэн үйл явцад Төв Азийн нүүдэлчин монгол, түрэг, тунгус угсаат ард түмэн түүхэн тодорхой үеүдэд шийдвэрлэх хийгээд шийдвэрлэх бүс үүрэг гүйцэтгэж ирснийг түүхнээс бид бэлхнээ мэднэ.

"Дундат зуун" судлаачид энэ үеийг дотор нь нийгэм, улс төр, эдийн засгийн хөгжлийн төвшин, агуулга, шинжлэх ухаан, соёлын дэвшил, хүний гоо сайхан, зан суртахууны философи нь гурав хуваадаг. Төгсгөлийг нь зөвхөн Европын хувьд 1492 он буюу Колумб Америкийг нээнээр, эсвэл 1453 он буюу Түрэгүүд, Константинополийг

<sup>2</sup> Н.Ишжамц. Монголд нэгдсэн улс байгулагдаж феодализм бүрэлдэн тогтсон нь. УБ., 1974.

<sup>3</sup> Н.Ишжамц. Мөн зоиол. х.25.

эзлэн авсанаар, эсвэл 1640 онд Англид хөрөнгөтний хувьсгал эхэлснээр тооцдог. Дорно дахинд бол бүр ч өөр байна. Энэ бол аливаа ард түмэн бүхэн түүхийн субъект, өөр өөрсдийн түүхэн хувь заяатай гэдгийг л нутлаж буй хэрэг. Тэдгээр гурван үе нь Өрнөдийн түүхчдийнхээр бол 1.Эртний "дундат зуун" /феодализм/ үүсч тогтсон үе /V-X зуун/, 2/ Хөгжингүй "дундат зуун" /феодализмын цэцэглэлтийн үе/ /XI-XV зуун/ 3/Хожмын "дундат зуун" буюу "түрүү шинэ үе" /XVI-XVII зууны эхэн хагас/ буюу феодализм бууран дорийтож мөхсөн үе эдгээр болно.

Тэгвэл Монголын түүхэнд "дундат зуун"-ы хөгжлийн ямар шатыг дамжиж, хэдийд шувтарсан бэ? гэдэг асуудал дэлхийн түүхийн нэгэн субъектийн хувьд зүй ёсоор тавигдаж байна. Орчин үед "нүүдлийн феодализм"-ын түүхийн судалгаа харьцаангүй нилээд хийгдсэн болохоор үүнд тулгуурлан энэ асуултад ямар нэгэн хэмжээгээр хариулахыг оролдье.

Нүүдлийн нийгэм нь хөгжлийн тодорхой зохих төвшинд хүрсэн хойноо гадны нөлөөгүй бол аль ч талаараа нийгэм, эдийн засаг, технологи соёлын төвшингөө удтал хадгалах чадавхитай байдаг. Иймээс ч нүүдэлчдийн мал аж ахуйг эрчимтэй юу? Эрчимгүй юу? Түүний цаашдын хувь заяаг яах вэ? гэсэн эдийн засаг, шинжлэх ухаан-улс төрийн асуудал, маргаан байнга гарсаар иржээ.

Бид энэ бяцхан өгүүлэлийн зорилго "дундат зуун" хэмээх түүхэн ойлголтын агуулга, орон, цагийн хүрээнд уг асуудалд хандаж байна.

Суурин феодализмын мөн чанарыг газар хэний эзэмшил, өмчинд байгаагаар тайлбарладаг бол, "нүүдлийн феодализмын" мөн чанарыг газар мал хоёрын харилцан шүтэлцээгээр тайлбарладаг нь онолын хувьд бүрэн нотлогдсон гэж үзэж болно. Чухам энэ онцлог байдал "нүүдлийн феодализм" хэмээх өвөрмөц нэр томъёо гараад хүргэсэн буй заа.

Монголын феодализмын түүхийг олон жилийн турш судалсан академич Ш.Нацагдорж "Монголын феодализмын үндсэн замнал" хэмээх тулгуур бүтээлдээ Монгол нутаг дахь феодаилзмын нийгмийн хөгжлийг дараах шатуудад хуваасан байх нь: 1. Монгол оронд феодалын харилцаа үүсч тогтсон нь, 2. Монголын феодализм цаашид хөгжсөн нь, 3. Феодалын бутрал, 4. Монголын феодализмын задрал /XIX зууны эцэс – XX зууны эхэн/, 6. Монголд феодалын ёсыг халсан нь гэсэн судалгааны үечлэлийг дэвшүүлсэн буй. Зохиогч энд "дундат зуун"-ы түүхийг үечлэх онол-арга зүйн зарчмыг баримтлан, дээрх судалгааны үечлэлийг түшиглэн Евроазийн улсуудын арт түмний түүхийг харгалзан үучир нь монголын эртний хийгээд дундат зууны нүүдэлчид тэдгээр улсуудын түүхэнд барагүй үүрэг гүйцэтгэсэн. У.Г./ Монголын "дундат зуун"-ы үеийг дараах байдлаар үечлэх үлгэр загварыг дэвшүүлж тус тусын онцлогийг гаргахыг оролдоо. Үүнд: Нэг. Монголын "дундат зуун" эрт үе. /МЭ IV-XII зуун/ буюу монголд феодалын харилцаа үүсч төлөвшсөн үе. Энэ үед Хүннү Сяньбин үед үр хөврөл нь тавигдсан эзэн харьяатын ёс Нирун Жужан/ улсын нийгмийн амьдралын бүх хүрээнд зонхилж, феодалжих үйл явц, эрчимжсэн юм. Ерөнхий түүхийн үүднээс авч үзвэл энэ нь нэг талаас газар малыг эзэмшихийн төлөө, нөгөө талаас малчин ардыг хараат хамжлага болгохын төлөөх тэмцлийн үе билээ. Энэ нь нийгмийн асар их зөрчил тэмцлийн дунд явагдаж байсан нь Нирун, Түрэг, Уйгур, Хятан улс X-XII зууны монгол аймаг ханлигуудын түүхнээс тодорхой байгаа билээ. Хоёр: Монголын хөгжингүй "дундат зуун"- үе. /XIII-XVII/ Энэ болон Монголд нэгдсэн улс байгуулагдаж феодалын үйлдвэрлэлийн харилцаа ялж, цаашид Монгол улс цэцэглэн хөгжсөн үе болно. Энэхүү хөгжил нь Монголын эзэнт гүрэн байгуулагдахад хүргэж, цаашид феодалын бутрал хэмээх нийгэм-улс төрийн үзэгдэл гараад шийдвэрлэх нелөө үзүүлжээ. Феодалын бутрал буюу төвөөс зугатаах үйл явц нь "дундат зуун"-ы үед энэ шатанд байсан түгээмэл үзэгдэл бөгөөд Европын улсууд төвлөрөх замд үүнд монголчуудын байлдан дагуулал барагүй үүрэг гүйцэтгэсэнийг судлаачид тэмдэглэдэг У.Г/ орж XV зуунд өнөөгийн Европын ихэнх улсууд нэгдсэн улс болсноор дууссан. Тэгвэл Монголын феодалын бутрал нь эсрэгээр, нэгдсэн улс, эзэнт гүрэн задарсны дараа буюу XV зуунаас эхэлжээ. Энэ нь "нүүдлийн феодализмын" өөрийнх нь хөгжлийн үр дагавар, онцлог мөн бөгөөд үүнд нүүдлийн мал аж ахуйн

өвөрмөц байдал, ахуй, хоцрогдол Монгол хаадын улс төрийн бодлогын доголдол, нүүдэлчдийн хувьд баримталж ирсэн "хятад" бодлого зэрэг олон хүчин зүйлүүдтэй холбоотой байна. Бутралын үеийн хаад төрийн зүтгэлтнүүдийн дотор төв рүү тэмүүлэх бодлого үе үе хүчтэй ажиглагдаж байсан нь түүхэн хөгжлийн жам юм. Хэрвээ гадаад хүчин зүйл байгаагүйсэн бол магад Монголын төвлөрсөн улс дахин байгуулагдах байсан гэдгийг үгүйсгэх аргагүй.

Гурав: Хожмын дундат зууны Монгол орон. /XVII зууны сүүлээс XX зууны эхэн үе/. Энэ бол харь гүрний эрхшээлд орж, тэдний төрийн бодлогын уршигаар Монгол орон улам бүр бутарч, нийгэм-эдийн засгийн хөгжил нь зогсонги байдалд орж, гадаадын капитал нэвтэрсэнээр таваар мөнгөний харилцаа хөгжин, дэлхийн зах зээлд татагдан орсноор феодалын нийгэм нь ялзран доройтож, бууран мөхсөн үе болно. Энэ үе бол нийгэм-улс төрийн хурц ширүүн тэмцлийн дунд өнгөрчээ. Түүний ноён оргил нь 1911 үндэсний, 1921 оны үндэсний ардчилсан хувьсгалууд болно. Монголд үеэ өнгөрөөсөн феодалын ёс /хамжлагат ёс/ 1924 он гэхэд бүрэн устсанаар Монголын "дундат зуун" шувтарч, дараагийн түүхэн үе "шинэ үе" эхэлжээ.

Үүгээр монголын "дундат зуун"-ыг дэлхийн дундат зууны түүхтэй холбох гэсэн оролдлогоо цэглэж, тэр нь нүүдлийн ахуй, соёлын онцлог, хийгээд дотоод, гадаад олон хүчин зүйлтэй холбоотойгоор өрнө дорнын улсуудтай зэрэгцүүлбэл харьцангуй удаан үргэлжилсэн агаад XIX-XX зууны монголын хоцрогдлын үндсэн шалтгааныг чухам үүгээр тайлбарлаж болно.

### **The Medieval Age in Mongolia.**

*By U.Gongorjav*

In this article touched the implication to the Mongolian History of the historical term "Medieval Age" by its historical categories and methodology. Wherein, Medieval Age in Mongolia could be classified in three periods:

1. The early Medieval Age (IV-XII centuries)
2. The Medieval Age (XIII-XVII centuries)
3. The Medieval Age (late XVII- early XX centuries)